



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 01/21

Чингис хот

Ц.Чогсомжавыг аймгийн Засаг даргын  
орлогчоор томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.2, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны "Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь хэсэгт аймгийн Засаг дарга нэгээс илүүгүй орлогчтой байна гэж заасны дагуу Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Цэнджавын Чогсомжавыг аймгийн Засаг даргын орлогчоор томилсугай.

2. Аймгийн Засаг даргын орлогч Ц.Чогсомжавын үндсэн цалинг 1051067 /нэг сая тавин нэгэн мянга жаран долоон/ төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар болон бусад нэмэгдлийг тооцож цалинжуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Ц.Чогсомжавт томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ харьяа Эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011118